



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/105

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх эрх олгох дуудлага
худалдааны тов зарлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 10 дугаар тогтоол, 2020 оны 152 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дүгээр сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх олгох дуудлага худалдааг явуулах 2 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, дуудлага худалдаа явуулах товын хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын
20 өдрийн А/10 тоот захирамжийн хавсралт

Хөвсгөл аймагт газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны газрын
байршил, эзэмших хугацаа, хэмжээ, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, явуулах хугацаа

№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх хугацаа	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ / төг/	Дэнчингийн үнэ /төг/	Дуудлага худалдаа явуулах хугацаа
1	13-р баг Дулааны станцын ар талд	Үйлдвэрлэлийн барилга байгууламж бусад газар	1309	3061438	15	5890500	589050	2023.04.24 өдрийн 9 цаг 00 мин-15 цаг 00 мин
2	8-р баг Авъяас сургуулийн зүүн талд	Ногоон байгууламж	831	3092212	15	6232500	623250	2023.04.24 өдрийн 9 цаг 00 мин-15 цаг 00 мин
Дүн							12123000	1212300

Handwritten signature